



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.08.02 № 01/684
танай _____ -ны № _____ -т

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ГАЛТ СУМЫН МОНГОЛ АРДЫН
НАМЫН ХОРООНЫ ДАРГА
Д.ПҮРЭВДОРЖ ТАНАА**

**Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөвсгөл аймгийн Галт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Хөвсгөл аймгийн Галт сумын Монгол Ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Хөвсгөл аймгийн Галт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Хөвсгөл аймгийн Галт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор Хөвсгөл аймгийн Галт сумын Монгол Ардын намын хорооны ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага болон холбогдох хууль, тогтоомжид тус тус нийцсэн байна.

Хөвсгөл аймгийн Галт сумын Монгол Ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөр (.ᠮ. хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Хөвсгөл аймгийн Галт сумын Монгол Ардын намын хороонд.

Хувийг: Хөвсгөл аймгийн Галт сумын Сонгуулийн хороонд.

Хавсралт .ᠮ. хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

Хөвсгөл аймгийн Галт сумын МАН-ын Хорооны
2024 оны 06 дугаар сарын 15 өдрийн 09 дүгээр
тогтоолоор батлав.



2024 ОНЫ СУМЫН ИТХ-ЫН СОНГУУЛЬД
МОНГОЛ АРДЫН НАМААС ДЭВШҮҮЛЖ БУЙ
“ГАЛТЫН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР”

Үндэслэл:

- Ард иргэд, албан байгууллага, төрийн бус байгууллагуудаас ирүүлсэн санал
- 2024 оны УИХ-ын сонгуульд МАН-аас дэвшүүлж буй мөрийн хөтөлбөр
- 2024 оны Аймгийн ИТХ-ын сонгуульд МАН-аас дэвшүүлж буй мөрийн хөтөлбөр
- Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал -2030
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль

Уриа: ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ БИД ХАМТДАА

Зорилго: Иргэдийнхээ хангалуун амьдрах, ажиллах, хөгжих боломжийг тэлсэн орчныг бий болгож, айл өрхийн амьжиргаа, аж ахуй нэгжийн үйл ажиллагааг дэмжсэн хөтөлбөрийг хэрэгжүүлж **ЭРЧИМТЭЙ** хөгжүүлнэ.

Үр дүн: ЭРҮҮЛ, БОЛОВСРОЛТОЙ, АЖИЛТАЙ ОРЛОГОТОЙ ИРГЭДТЭЙ,
АЯ ТУХТАЙ ОРЧИН

Нэг: ХҮМҮҮНИЙ ХӨГЖИЛ

1.1 Хүүхэд бидний - ИРЭЭДҮЙ

- Хүүхдийг халдварт өвчинөөс урьдчилан сэргийлэх үзлэг, вакцинд тогтмол хамруулж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.
- СӨБ-ын хүртээмжийг дээшлүүлж, багийн болон хөгжлийн бэрхшээлтэй, эмзэг бүлгийн хүүхдийн хамрагдах нөхцлийг бүрдүүлнэ.
- Нүүдлийн болон зуны цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлж үргэлжлэх хугацааг уртасган, чанарыг сайжруулахад иргэд, хувийн хэвшлийг дэмжиж ажиллана.
- “Галтын бахархал”, “Зөв хүүхэд-Сайн хүмүүжил”, “Авъяаслаг Галтчууд” “Оюунлаг Галтынхан” хөтөлбөрийг хэрэгжүүлж ёс заншил, түүх соёл, төрөлх нутаг байгалиа хамгаалах, бахархах, эх оронч үзлийг төлөвшүүлнэ.
- “Хүүхэд гэр бүлийн аз жаргал” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- Хүүхдийн хөгжлийг дэмжих чиглэлээр олон улсын төсөл, арга хэмжээг нэмэгдүүлнэ.

1.2 Залуус бидний – ИТГЭЛ

1720090001 0070605

0000000001

- “Оюунлаг Галтынхан” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- “Бүтээлч залуу” хөтөлбөрийг хэрэгжүүлэн залуусыг хөдөлмөр эрхлэхэд нь дэмжин ажиллана.
- Суманд хийгдэж буй томоохон бүтээн байгуулалтын ажлуудыг сумандаа хийж хэрэгжүүлэх /тендер/ бололцоо нөхцөлийг судлаж орон нутгийн залуучуудыг татан оролцуулж ажлын байр бий болгоно.
- “Эрүүл Галтчууд” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж залуучуудыг жилд нэг удаа эрүүл мэндийн бүрэн оношилгоонд заавал хамруулна.
- Эрэлттэй ажлын байрны судалгааг гаргаж энэ чиглэлээр аймгийн МСҮТ-д дунд, богино хугацааны сургалтанд хамруулна.

1.3 Эмэгтэйчүүд бидний -ТҮШИГ

- “Ээжээ тандаа баярлалаа” хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ
- Эмэгтэйчүүдийг эрүүл мэндийн үзлэг оношлогоонд хамруулах цогц аяныг өргөн цар хүрээтэйгээр уламжлал болгон зохион байгуулна.
- Эмэгтэйчүүдийн нийгмийн оролцоог дэмжсэн төсөл хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- Эмэгтэйчүүдийн хийсэн гар урлалын бүтээгдэхүүнийг дэмжиж борлуулалтын суваг бий болгоно.
- Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зээл бусад төсөл хөтөлбөрүүдээс санхүүждэг зээл тусламжийн тодорхой хувийг ганц бие, өрх толгойлсон эмэгтэйчүүдийг дэмжихэд чиглүүлнэ.

1.4 Ахмадууд бидний - БАХАРХАЛ


- “Ахмадуудаа дээдлэн хайрлая” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- Мэргэжлийн салбар бүрт ахмадын зөвлөл ажиллуулж, санал санаачлагыг нь бодлогын баримт бичиг, үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлнэ.
- Сумын ахмадуудыг Галт халуун рашаан сувилалд амруулж сувилуулах ажлыг жил бүр зохион байгуулна..
- Ахмад настны нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх тусгай сан баг бүрт байгуулах
- Ахмад настныг нийтийн тээврээр үнэгүй зорчих эрх зүйн зохицуулалтыг хэрэгжүүлэн ажиллана

1.5 Бизнес эрхлэгч - Баялаг бүтээгчид бидний – ХӨГЖИЛ Баялаг бүтээгчдээ дэмжих:

- “Бизнэс эрхлэгч - Баялаг Бүтээгч” хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- Төрийн болон төсөл хөтөлбөрийн эх үүсвэрээр хөнгөлөлтэй зээл, тусламжинд хамруулна.
- “Галтын бренд”-ийн бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах, сүү цагаан идээг худалдан борлуулах зах зээлийн гарц боломжийг бүрдүүлнэ.
- Төрөөс үйлдвэрлэгч, баялаг бүтээгчийн хөдөлмөрийг үнэлж дүгнэх, шагнаж урамшуулахад анхаарна.

Малчид, төмс хүнсний ногоо тариалагчдаа дэмжих:

- Малчидаа дэмжих бодлогын хүрээнд жилд 50 өрхийг малжуулах хөтөлбөрт хамруулна. Дэлхийн зөн ОУБ



0000000002

- Мал, малын гаралтай түүхий эдийг гадаад дотоодын зах зээлд худалдан борлуулах дэмжлэг үзүүлнэ.
- Эрчимжсэн болон туслах аж ахуйг бүс нутгийн онцлогт тохируулан хөгжүүлж, малын тэжээл тариалах, бүрэн найрлагат тэжээлийг үйлдвэрлэхэд хувийн хэвшил, малчдын оролцоог дэмжинэ.
- Мал амьтны гаралтай өвчний тандалт, хяналтыг тогтмолжуулж, өвчний голомтыг устгах, ариутгах халдваргүйжүүлэх ажлыг зохион байгуулж, мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөлийг бүрдүүлнэ.
- Төмс хүнсний ногоо тариалагчидад төмс хүнсний ногоо тарих талбай, усан хангамж, хүлэмж, зорьтой болоход сумаас дэмжих замаар төмс хүнсний ногоогоор сумын хэрэгцээг хангана.



Хоёр: ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИНЫ ХӨГЖИЛ

2.1 Ая тухтай орчин - НОГООН ХӨГЖИЛ

- Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, төлөвлөлттэйгээр хөгжүүлнэ.
- “Найрсаг Галтчууд” хөтөлбөрийг хэрэгжүүлж сумандаа сайхан амьдрах боломжийг бүрдүүлнэ.
- “Хашаандаа тохилог сайхан амьдарцгаая” хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.
- Сумын “Тохижилт, ногоон байгууламж”-ийн төв байгуулж Галт сумыг “Ногоон сум” болох хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- Суманд хувийн хэвшлийн оролцоотойгоор дэвшилтэт технологи бүхий:
 - Усалгаатай цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ
- Сумдын хилийн цэсийг малчид иргэдэд тодорхой болгож тэмдэгжүүлнэ

2.2 Эрүүл аюулгүй соёлтой амьдрахад таатай - ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ

- Жишиг сум болгох саналыг дэвшүүлж, шийдвэрлүүлнэ.
- Сумын төв доторх 3 км төв замыг хатуу хучилттай болгох асуудлыг шийдвэрлүүлж ашиглалтанд оруулна.
- Архангайн Тариат - Мөрөн чиглэлийн “Аялал жуулчлал”-ын босоо тэнхлэгийн 285 км замын зураг төсвийг Нүхт багийн төвөөр дамжин өнгөрөхөөр өөрчилж барих асуудлыг шийдвэрлүүлнэ.
- Сумын төвийн урд талаар Харцатын голд төмөр бетон гүүр тавина.
- “Сумын эрчим хүчний мастер төлөвлөгөө”-г батлуулан хэрэгжилтийг хангаж, дараах хөрөнгө оруулалтыг онцгойлон шийдвэрлэнэ
 - Эрдэнэт Мөрөнгийн эрчим хүчний шугамнаас Галт сумыг 35 кВ өндөр хүчдэлийн шугманд холбогдох асуудлыг шийдвэрлүүлж сумын эрчим хүчний доголдолыг арилгана.
- Сумын төвийн худгуудад ус цэвэршүүлэх шүүлтүүр тавьж стандартын шаардлага хангасан усаар ард иргэдийн хэрэглээг бүрэн хангах ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.



 0000000003

- Нийтийн тээврийн үйлчилгээг дэмжиж бага оврын автобус, такси үйлчилгээг дэмжиж ажиллана.

2.4 Амьд байгаль -АЮУЛГҮЙ ИРЭЭДҮЙ

- Байгаль цаг уур, уур амьсгалын өөрчлөлт хуурайшилтын эсрэг усан сан хөв цөөрөм байгуулах ажлыг санаачлан зохион байгуулж ажиллана
- Хэрэглээний модны зөвшөөрлийг нэмэгдүүлэх замаар хөдөөгийн багийн иргэдийг өвөл, зуны орон сууцтай болоход дэмжлэг үзүүлнэ.
- Ойн дагалт баялаг, байгалийн ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэх бүсийг баг бүрээр тогтооно.
- Бэлчээрийн талхлагдал, цөлжилтийн талаар иж бүрэн судалгаа хийж, хамгаалалтын менежментийг боловсруулан хэрэгжүүлнэ
- Ойн хөнөөлт шавжийн тархалт, өсөлт бууралтыг хяналтанд авч, зарцуулах хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлнэ.
- Байгалийн баялагаас орж байгаа орлогын тодорхой хувийг байгаль хамгаалах нөхөн сэргээх үйл ажиллагаанд зарцуулна.
- Байгалийн аясаар болон зориудаар ойжуулж нөхөн сэргээх талбайн хэмжээг нэмэгдүүлнэ.

ГУРАВ: ХҮРТЭЭМЖТЭЙ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

3.1 “Эрүүл хүн жаргалтай” эрүүл мэндийн үйлчилгээ.

- “Эрүүл Галтчууд хөтөлбөр”-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж сумын иргэдийг жилд 2-оос доошгүй удаа эрүүл мэндийн үзлэг оношлогоонд хамруулах боломжийг бүрдүүлнэ.
- Эх хүүхдийн эндэгдлийг тууштай бууруулж, Хүүхдэд ээлтэй сум болох зорилтыг тодорхойлж хэрэгжүүлэн ажиллана.
- Эмийн аюулгүй байдал,эмийн үнэнд хяналт тавьж, стандартын шаардлага хангасан, хямд эмийн үйлчилгээг үзүүлэхэд онцгойлон анхаарч ажиллана.
- Хүн амыг аюулгүй ус, хүнсээр хангах, орчны ариун цэврийн байдлыг сайжруулахад чиглэсэн бодлого хэрэгжүүлнэ.
- “Эх хүүхдийг эрсдлээс хамгаалах” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ
- Элэг бүтэн Монгол хөтөлбөрийн хүрээнд нийт иргэдийг элэгний вирусийн шинжилгээнд хамруулж эмчилнэ.

3.2 Оюунлаг-Галтчууд - Боловсрол, соёлын үйлчилгээ.

- “Багшийн хөгжил” хөтөлбөрийг хэрэгжүүлэх замаар массын сургалтын чанар, үр дүнд ахиц гаргана.
- Иргэд, төрийн албан хаагчдын эх хэл, англи хэл, гадаад хэлний чадвар хэрэглээг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллана.
- Сургууль, цэцэрлэгийн орчны стандартыг хангахад шаардлагатай камержуулалтыг шийдвэрлэнэ.



 0000000004

- Сургуулийг байгалийн ухааны хичээлийн сорилт туршилт, судалгаа хийх лабораторитой болгоно.
- Гэгээрэл төвийг орон нутгийн онцлогтой уялдуулан амьдрах ухаан, эрүүл мэнд, мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл, техник технологийн чиглэлийн багшлах хүний нөөцөөр хангаж, үйл ажиллагааг тогтмолжуулна.
- Соёлын салбарын хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- Нийтийн номын санг цахим хэлбэрт шилжүүлж, орчин үеийн шаардлагад нийцүүлэн хөгжүүлж, хүний нөөцийг чадавхжуулна.
- Сумын соёлын төвийн орчин нөхцөл, техник хэрэгсэл, материаллаг баазыг бэхжүүлнэ.

3.3 Зорилтод бүлэгт чиглэсэн нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр .

- “Ажилтай иргэн-Амьжиргаатай өрх” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- Хүн амыг эрүүл урт насжилтанд бэлтгэх, тогтмол орлогын эх үүсвэртэй байлгах нөхцөлийг бүрдүүлж, амьдралын чанарыг сайжруулна.
- Нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлж, чанар хүртээмжийг сайжруулан олон талт үйлчилгээг хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын оролцоотойгоор хэрэгжүүлэх аргыг боловсронгуй болгож дэмжинэ.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бүлэг нөхөрлөлийг дэмжиж ажлын байраар хангаж ажиллана.
- Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ зэрэг өрхийн орлогыг нэмэгдүүлэх нийгмийн олон талт арга хэмжээнд зорилтот бүлгийн өрхийг нэн тэргүүнд хамруулж өрхийн орлогыг нэмэгдүүлнэ.

3.4 Сайн засаглал – Найрсаг үйлчилгээ

- Бүх түвшиний төрийн байгууллагыг цахим болгож үйлчилгээ, мэдээллийг сайжруулна.
- Төсөл хөтөлбөрийн сонгон шалгаруулалт, хэрэгжилтэнд хяналт тавьж ажлын байр, үр өгөөжийг тооцож ажиллана.
- Шийдвэр гаргах явцад иргэний нийгмийн оролцоог хангах, төр-иргэний нийгмийн бүх талын түншлэлийг хөгжүүлнэ.
- Төрийн зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр хувийн хэвшил болон төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, төр, иргэний нийгэм, бизнесийн байгууллагуудын түншлэлийг өргөжүүлнэ.
- Төсөв санхүү, хөрөнгө оруулалт, худалдан авах, хүний нөөц, үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэд, иргэний нийгмийн байгууллагын тэгш оролцох боломжийг бүрдүүлнэ.
- Төрийн албан хаагчийн ёс зүйн үнэлэмж, төлөвшилийг төрийн албаны үндсэн шалгуур болгож хариуцлага сахилга ажлын үр дүнг чанга хатуу тооцож ажиллах болно.
- “Хариуцлага, хамтын ажиллагаа” хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.



0000000005

- Иргэнийхээ үүсгэл санаачлагаар байгуулагдсан иргэний нийгмийн байгууллага, холбоо, нөхөрлөл, хоршооны үйл ажиллагааг бодлогоор дэмжиж ажиллана.
- Соёл, боловсрол, аялал жуулчлал, бизнесийн чиглэлээр гадаад харилцааг өргөжүүлж, олон талт шинэ түвшинд гаргана.

ДӨРӨВ: ХӨГЖИЛД ХӨТӨЛСӨН ҮЙЛДВЭРЖИЛТ

4.1 Үйлдвэржилт –ХӨГЖЛИЙН БОЛОМЖ


- Орон нутгийн түүхий эдийг ашиглан нэмүү өртөг шингээж импортыг оролсон экспортод чиглэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрлэлийг бүх талаар дэмжинэ
- Төрийн худалдан авалтанд орон нутгийн үйлдвэрүүдэд давуу эрхийг олгоно
- Орон нутагт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг түлхүү хэрэглэхийг иргэддээ уриална
- Үйлдвэр эрхлэгчид, ард иргэдийг хөнгөлттэй зээлээр дэмжинэ .
- Аймаг, Улаанбаатар болон бусад суурин газруудад үзэсгэлэн худалдаануудад зохион байгуулалттай оролцуулж, бүтээгдэхүүнийг сурталчилна

4.2 Аялал жуулчлал- ХӨГЖЛИЙН ГАРЦ

- “Аялал жуулчлалаас орон нутагт орох орлогын хэмжээг нэмэгдүүлнэ.
- Галт халуун ус рашаан сувлал, Тэмээн чулууны хяр бусад түүхийн дурсгалт газруудыг холбосон аялал жуулчлалын маршрут гарган аялал жуулчлалын бүс нутаг болгон хөгжүүлнэ.
- Аялал жуулчлалын бүтээгдэхүүний нэр төрлийг тогтмол нэмэгдүүлж, түүх, соёлын аялал жуулчлалыг дэмжинэ
- Дотоодын амрагч, аялагчдад зориулсан амралт зугаалгын бүсчлэлийг тогтоож, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал, гар урлалын үйлдвэрлэлийг хөгжүүлнэ

4.3 Хөдөө аж ахуй, байгалийн баялагт түшиглэсэн үйлдвэрлэл-ХӨГЖЛИЙН ТУЛГУУР

- Малчдын нэгдэх, хорших үйл ажиллагааг дэмжин хөгжүүлнэ.
- Ногоон тэжээл төмс хүнсний ногоо тариалалтыг нэмэгдүүлж орон нутгийн хэрэгцээг хангана.
- Үйлдвэрийн аргаар бэлтгэсэн мал амьтны болон байгалийн гаралтай эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.
- Ажлын байрыг олноор бий болгох томоохон үйлдвэрүүдийг дэмжин хөгжүүлнэ
- Эрчимжсэн фермерийн аж ахуй, туслах аж ахуйг хөгжүүлнэ. (гахай, тахиа, зөгий гэх мэт)
-


9070605

0000000006

ТАВ: ГАДААД ХАРИЛЦАА-ХАМТЫН АЖИЛЛАГАА

5.1 Хөдөө аж ахуй, байгалийн баялагт тулгуурласан үйлдвэрлэл, орон нутгийн дэд бүтцийн хөгжлийг шинэ шатанд гаргана.

- Нутгийн зөвлөлүүдийн хамтын ажиллагааг өргөжүүлэн орон нутгийн хөгжил, бүтээн байгуулалтын ажилд чиглүүлэн ажиллана.
- Нэгдсэн үндэсний байгууллага, Дэлхийн зөн ОУБ, Өвсний үндэс төсөл, Азийн хөгжлийн банк, Мерси-кор зэрэг олон улсын байгууллагатай жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, орон нутгийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, малчдын амьжиргааг нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажиллана.
- Япон улсын ОИТА аймгийн USASHI хотын захиргаатай шефийн харилцаа, хамтын ажиллагаатай болж ажиллах хүчин нийлүүлэх, аялал жуулчлал, үйлдвэрлэлийг хөгжүүлэх, орон нутгийн дэд бүтцийг сайжруулах чиглэлээр хамтран ажиллана.



ХӨВСГӨЛ АЙМГИЙН ГАЛТ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМ 0070605



0000000007